



МОНГОЛ УЛСЫН
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙДЫН
ТУШААЛ

2024 оны 05 сарын 31 өдөр

Дугаар 7/2005

Улаанбаатар хот

Дүрэм батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.13 дахь заалт, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Цэргийн алба хаагчийн ёс зүйн дүрэм"-ийг хавсралтаар баталсугай.

2. Хавсралтаар батлагдсан дүрмийг цэргийн алба хаагчдад танилцуулж, дүрмийн хэрэгжилтийг ханган ажиллахыг Батлан хамгаалах яам (бригадын генерал Д.Ганхуяг), Зэвсэгт хүчний Жанжин штаб (хошууч генерал С.Ганбямба), төрлийн цэргийн командлал, удирдах газар, харьяа нэгтгэл, анги, байгууллагын захирагч, дарга нарт үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (хурандаа Н.Пүрэвдорж)-т даалгасугай.


САЙД



Г.САЙХАНБАЯР

1324100400

Батлан хамгаалахын сайдын 2024 оны
05 дугаар сарын 31-ны өдрийн
А/005 дүгээр тушаалын хавсралт



ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Цэргийн алба хаагчийн ёс зүйн дүрэм (цаашид “Ёс зүйн дүрэм” гэх)-ийн зорилго нь Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд батлан хамгаалах салбарын хуульд заасан чиг үүргийн онцлогт нийцүүлэн цэргийн алба хаагчийн баримтлах ёс зүйн зарчим, хэм хэмжээ, шаардлагыг тогтоон хэвшүүлэх, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэх, цэргийн алба хаагчид ёс зүйн хариуцлага ногдуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Дүрмийн 1.1-д заасныг Төрийн албаны тухай, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай, Цэргийн албаны тухай, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай, Авлигын эсрэг хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомж, энэхүү дүрмийн хүрээнд хэрэгжилтийг хангаж ажиллана.

1.3. Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб, төрлийн цэргийн командлал, удирдах газар, нэгтгэл, анги, байгууллагын удирдах албан тушаалтан нь өөрийн эрхэлсэн асуудлын хүрээний байгууллагын цэргийн алба хаагчийн ёс зүйн байдалд хяналт тавьж, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон энэ дүрмээр зохицуулсан хэм хэмжээг сахин мөрдөх нөхцөлийг бүрдүүлэх үүргийг хүлээнэ.

1.4. Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб, төрлийн цэргийн командлал, удирдах газар, нэгтгэл, анги, байгууллага нь “Ёс зүйн дэд хороо”-той байна.

1.5. Дүрмийн 1.4-д заасан байгууллагын дарга (захирагч) нар Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд заасан Ёс зүйн дэд хорооны ажиллах журмыг баримталж, ажиллах нөхцөл, боломжоор хангана.

Хоёр. Ёс зүйн дүрмийн үйлчлэх хүрээ

2.1. Энэхүү дүрмийн үйлчлэх хүрээнд Зэвсэгт хүчний цэргийн жинхэнэ албаны бие бүрэлдэхүүн (цаашид “цэргийн алба хаагч” гэх) хамаарна.

2.2. Цэргийн алба хаагч гадаад улсад албан томилолтоор ажиллах, гадаадын цэргийн сургуульд суралцах, энхийг дэмжих ажиллагаанд оролцох үед Ёс зүйн дүрэм нэгэн адил үйлчилнэ.

2.3. Ёс зүйн зөрчил гаргасан тухай өргөдөл, гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэх ажиллагааг Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Ёс зүйн дэд хорооны ажиллах журмын дагуу тус тус зохион байгуулна.

Гурав. Цэргийн алба хаагчийн ёс зүйн андгай, зарчим

3.1.Цэргийн алба хаагч нь албан үүргээ гүйцэтгэхдээ хууль тогтоомжид заасан ёс зүйн хэм хэмжээг сахин мөрдөж, ёс зүйн зөрчил гаргахгүй байхаа андгайлж “Цэргийн алба хаагчийн ёс зүйн андгай”-г өргөж, гарын үсэг зурж баталгаажуулна.

3.2.“Цэргийн алба хаагчийн ёс зүйн андгай”:

Цэргийн алба хаагч нь албан үүргээ гүйцэтгэхдээ “Эх орон, ард түмнийхээ төлөө эрдэм мэдлэг, хүч чадлаа зориулж, Монгол Улсын Үндсэн хууль, Цэргийн нийтлэг дүрмүүд, Цэргийн алба хаагчийн ёс зүйн дүрмийг чанд сахин биелүүлж, цэргийн алба хаагчийн нэр хүндийг өндөрт өргөж, захирах, захирагдах ёсыг эрхэмлэн дээдэлж, албан үүргээ үнэнч шударгаар биелүүлэхээ андгайлъя.” гэж андгай өргөнө.

3.2.1.Цэргийн алба хаагчийн ёс зүйн андгай өргөх ажиллагааг Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб, төрлийн цэргийн командлал, удирдах газар, нэгтгэл, анги, байгууллагын дарга (захирагч), хүний нөөцийн асуудал эрхэлсэн нэгж хариуцан зохион байгуулна.

3.3.Цэргийн алба хаагч нь үйл ажиллагаандаа Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 6.1 дэх хэсэг, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3.1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2022 оны 180 дугаар зарлигаар батлагдсан “Цэргийн дотоод албаны дүрэм”-ийн 4 дүгээр зүйлд заасан зарчмыг баримтална.

Дөрөв.Цэргийн алба хаагчийн ёс зүйн хэм хэмжээ

4.1.Цэргийн алба хаагч нь Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 7.1 дэх хэсэгт заасан ёс зүйн нийтлэг хэм хэмжээнээс гадна дор дурдсан ёс зүйн хэм хэмжээг сахин мөрдөнө:

4.1.1.хууль ёсыг үг, үйлдэл, ёс зүй болон зан суртахуунаараа эрхэмлэн дээдлэх;

4.1.2.үнэнч, шударга байж, хувийн ашиг сонирхлоос ангид байх;

4.1.3.бусдын нэр төр, алдар хүнд, эмзэг мэдээлэл, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэж, батлан хамгаалах салбарын нэр хүндийг эрхэмлэх;

4.1.4.албан үүргээ гүйцэтгэхдээ гаргасан буруутай үйлдэл, эс үйлдэхүйг ухамсарлах, ёс зүйн хариуцлага хүлээдэг байх;

4.1.5.улс төрийн аливаа нам, эвсэл, хөдөлгөөний үйл ажиллагаанаас ангид байх;

4.1.6.өргөсөн тангарагтаа үнэнч байж, захирах, захирагдах ёсыг сахин биелүүлэх.

Тав.Цэргийн алба хаагчид тавих ёс зүйн шаардлага

5.1.Цэргийн алба хаагч нь үйл ажиллагаандаа Төрийн албаны тухай, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай

хуульд заасан үүрэг, хязгаарлалт, ёс зүйн нийтлэг шаардлагаас гадна доор дурдсан ёс зүйн шаардлагыг биелүүлэх үүргийг хүлээнэ:

5.1.1.энэхүү дүрмийн 1.2-т заасан хууль тогтоомж, энэхүү дүрмийг чанд баримтлах;

5.1.2.хууль зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйн талаар олж мэдсэн мэдээллийг холбогдох эрх бүхий албан тушаалтан, байгууллагад мэдэгдэх;

5.1.3.байгууллагын кибер аюулгүй байдлыг хангах;

5.1.4.эрх бүхий албан тушаалтны баталсан байгууллагын хөдөлмөрийн болон дотоод журмыг чанд сахин биелүүлэх;

5.1.5.хууль ёсны шаардлага тавих, хууль бус үүрэг даалгавар гүйцэтгүүлэхгүй байх.

5.1.6.авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;

5.1.7.хууль бусаар өөрт болон бусдад давуу байдал олгохгүй байх;

5.1.8.цахим гэмт хэргийн шинжтэй үйл ажиллагаанд элсэх, оролцох, бусдыг оролцохыг ятгах, элсүүлэх, цахим орчинд мөрийтэй тоглохгүй байх;

5.1.9.жендерийн ялгаварлан гадуурхалт, ажлын байрны бэлгийн дарамт, шахалтаас ангид байх;

5.1.10.гадаад улс оронд үүрэг гүйцэтгэхдээ тухайн улсын зан заншлыг хүндэтгэх;

5.1.11.ажлын байранд болон олон нийтийн газарт мөрдөх дэг журмыг сахих, биеэ зөв авч явах, бүдүүлэг зан авир гаргахыг цээрлэх;

5.1.12.байгууллагын дотоод журамд заасан хувцаслалтын шаардлагыг баримтлах;

5.1.13.байгууллагын үйл ажиллагааг мушгин гуйвуулах, хамт олны эв нэгдлийг хагарган бутаргах, үндэслэлгүй худал мэдээ, мэдээлэл тараах, бусдыг тохуурхан хочлох, үндэслэлгүй гүтгэхийг хориглох (цээрлэх).

5.1.14.албаны үйл ажиллагаатай холбогдох асуудлаар хэвлэл мэдээллийн байгууллагад зөвхөн удирдлагын зөвшөөрөлтэйгөөр мэдээлэл өгөх;

5.1.15.албан бус мэдээ, мэдээлэл, бусдын дам үгийг үндэслэн аливаа шийдвэр гаргахгүй байх;

Зургаа.Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх

6.1.Ёс зүйн дэд хороо, томилох эрх бүхий албан тушаалтан нь Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, "Төрийн албан хаагчийг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх Үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх арга хэмжээг уялдуулан цэргийн алба хаагчийг ёс зүйн

зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр тодорхой, үр дүнтэй ажил, арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж, холбогдох эрх бүхий байгууллагад хуульд заасны дагуу тайлагнана.

6.2.Цэргийн жинхэнэ албанд анх томилогдсон алба хаагчийг цэргийн алба хаагчийн ёс зүйн тухай, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх сургалт, ажил, арга хэмжээнд заавал хамруулна.

6.3.Цэргийн алба хаагчийн ажлын гүйцэтгэлийг нь үнэлэх, албан тушаалд дэвшүүлэх, шагнал, урамшуулал олгох асуудлыг шийдвэрлэхдээ ёс зүйн хариуцлага хүлээсэн эсэхийг харгалзана.

6.4.Цэргийн жинхэнэ албан хаагч нь цэргийн бэлтгэл алба хаагчдад ёс зүйн үлгэрлэл үзүүлэх, байгууллагаас ёс зүйгээр манлайлагч цэргийн алба хаагчийг олон нийтэд сурталчлан таниулах, нийгэмд ёс зүйн зэрэг нөлөөллийг нэмэгдүүлнэ.

Долоо.Цэргийн алба хаагчид ёс зүйн хариуцлага ногдуулах

7.1.Цэргийн алба хаагчийн ёс зүйн зөрчил гэж Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 5.1.2-т зааснаас гадна цэргийн алба хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг ойлгоно.

7.2.Энэ дүрэмд заасан ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн цэргийн алба хаагчид тухайн байгууллагын Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн зөрчлийн шинж байдал, анх буюу давтан үйлдсэнийг нь харгалзан Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасан ёс зүйн хариуцлага ногдуулна.

7.3.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэгт заасны дагуу тухайн байгууллагын Ёс зүйн дэд хорооны дүгнэлтээр тухайн цэргийн алба хаагч ёс зүйн зөрчил гаргасан нь тогтоогдсон бол түүнд албан ёсоор мэдэгдсэнээр хариуцлагыг сайн дураараа хүлээх боломж олгоно.

7.4.Цэргийн алба хаагч нь Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсэгт заасан ёс зүйн хариуцлагыг сайн дураараа хүлээж болно.

БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМ